



СЕКЮРИТИЗ  
ҮЦК

**ГАДААД ЗАХ ЗЭЭЛИЙН ТОЙМ**

**2022.03.28-2022.04.01**

---




# ГАДААД ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ТОЙМ

2022.04.04-ний байдлаар

АНУ	Ханш	Өөрчлөлт	7 хоног	1 Сар	Он гарснаас хойш
US30	34,818.27	0.40%	-0.49%	5.99%	3.75%
US500	4,545.86	0.51%	-0.76%	8.08%	11.35%
DOW	14,261.50	0.29%	-1.08%	11.31%	9.06%
Европ	Ханш	Өөрчлөлт	7 хоног	1 Сар	Он гарснаас хойш
GB100	7,537.90	0.30%	0.73%	1.46%	10.47%
DE40	14,446.48	0.22%	0.98%	3.19%	-5.04%
FR40	6,684.31	0.37%	1.99%	2.87%	9.02%
IT40	25,163.30	0.57%	2.46%	2.56%	1.62%
ES35	8,503.70	0.69%	2.08%	2.20%	-1.52%
Ази	Ханш	Өөрчлөлт	7 хоног	1 Сар	Он гарснаас хойш
JP225	27,667.00	0.00%	-1.64%	4.90%	-7.26%
SHANGHAI	3,283.00	0.94%	2.19%	-5.78%	-5.79%
CSI 300	4,276.00	1.27%	2.43%	-6.61%	-17.15%
SHANGHAI 50	2,943.00	1.53%	3.04%	-5.28%	-18.62%
CH50	14,009.59	1.88%	3.55%	-5.11%	-20.95%
SENSEX	59,277.00	1.21%	3.34%	6.86%	20.58%
Эрчим хүч	Ханш	Өөрчлөлт	7 хоног	1 Сар	Он гарснаас хойш
Газрын тос (Crude Oil)	99.09	-0.18%	-6.48%	-14.43%	68.95%
Газрын тос (Brent)	104.11	-0.26%	-4.93%	-12.43%	67.13%
Байгалийн хий	5.7460	0.49%	4.28%	18.48%	128.04%
Шатахуун	3.1503	-0.12%	-1.48%	-10.76%	60.56%
Нүүрс	258.75	-1.99%	-20.91%	-35.31%	168.13%
Түүхий эд	Ханш	Өөрчлөлт	7 хоног	1 Сар	Он гарснаас хойш
Алт	1918.89	-0.28%	-0.24%	-3.98%	11.00%
Мөнгө	24.572	-0.15%	-1.14%	-4.29%	-1.20%
Зэс	4.70	0.32%	-0.34%	-0.50%	13.24%
Бонд /10 жил/	Өгөөж	Өөрчлөлт	7 хоног	1 Сар	Он гарснаас хойш
АНУ	2.4152	0.0257	-0.05%	0.64%	0.70%
Англи	1.6050	0.0200	-0.09%	0.35%	0.81%
Швейцар	0.6150	0.0220	0.05%	0.45%	0.98%
Испани	1.4970	0.012	0.04%	0.49%	1.18%
Португаль	1.3990	0.0280	0.07%	0.56%	1.16%

Эх сурвалж: Trading economics





Эх сурвалж: Business Insider

# ДЭЛХИЙН ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДАЛ

## АНУ

### Хөрөнгийн зах зээл энэ оны эхний улиралд уналттай хаалаа

АНУ-ын хөрөнгийн зах зээлийн индексүүдийн 2022 оны эхний улирлын ханшийг 2021 оны эцэстэй харьцуулахад илүү доогуур хаагдлаа. Жишээлбэл, S&P 500 -5.0%-ийн уналттай хаасан нь 2020 оны эхний улирлын үеэс хойш сүүлийн 2 жилийн доод ханшид хүрсэн уналт юм. Бодлогын хүү өсөж байгаа болон Орос–Украины дайны нөхцөл байдалтай үе тохиож байгаа ч сүүлийн хэдэн 7 хоногт хөрөнгийн зах зээл 1-р улирлын доод түвшнээс 10%-иар өссөн үзүүлэлттэй хаасан юм.

Шинжээчид цаашид хөрөнгийн зах зээл хэр өсөхийг дараах 2 эдийн засгийн хүчин зүйлсээс шалтгаална гэж харж байна:

- 1. АНУ-ын худалдан авагчдын хандлага эерэг байна.** Хэрэглээний зардал хэдий өсөж байгаа ч АНУ-ын худалдан авалтын хэмжээ хэвийн байгаа нь эдийн засаг харьцангуй сайн байгааг илтгэж байна. Өнгөрсөн Баасан гарагийн мэдээгээр ажилгүйдлийн түвшин 3.6%-д хүрсэн, дундаж цагийн цалин өнгөрсөн жилийнхээс 5.6%-иар өссөн, мөн ажиллах хүч 62.4%-д хүрсэн зэрэг нь эдийн засаг сэргэж байгаагийн илэрхийлэл болж байна. АНУ-ын өрхийн банкин дахь хадгаламж 2.5 их наяд долларт хүрсэн нь эдийн засагт тулгарч болох шокийг даван дуулахад томоохон дэм болж өгөхөөр байна.



- 2. Компаниудын санхүүгийн тайлангаар ашгийн үзүүлэлт сайн байгааг харуулж байна.** Энэ жилийн санхүүгийн тайлангууд 4 сарын дундаас эхэлж олон нийтэд бэлэн болно. Шинжээчдийн үзэж байгаагаар 2022 онд компаниудын санхүүгийн байдал өмнөх жилийнхээс илүү сайн байхаар таамаглаж байна. S&P 500 индексийн төсөөлөл 2021 оны эцэст 7% байсан бол энэ оны улирлын эцэст 9.1% болон өсжээ.

Эх сурвалж: [www.edwardjones.com](http://www.edwardjones.com)




# ДЭЛХИЙН ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДАЛ

**Бондын өгөөжийн зөрүү сөрөг болох нь эдийн засгийн хямралын дохио болж өгдөг**

Хөрөнгийн зах зээл өнгөрсөн сард өсөлттэй байсан бол бондын зах зээл илүү анхааруулах дохио өгсөн юм. Энэхүү анхааруулах дохио нь АНУ-ын 10 жилийн урт хугацаатай үнэт цаасны өгөөж 2 жилийн богино хугацаатай өгөөжөөс бага болсонд байгаа юм.

Урт хугацаатай бондын өгөөж богино хугацаат бондын өгөөжөөс бага болно гэдэг нь хөрөнгө оруулагчид ирээдүйд эдийн засгийн хямрал болж магадгүй гэж үздэг.

2 ба 10 жилийн хугацаатай бондын өгөөжийн зөрүү сөрөг болов



Хэдийн бондын өгөөжийн зөрүү сөрөг болсон ч эдийн засгийн хямрал тодорхой хугацааны дараа болдог. Түүхээс харахад бондын өгөөжийн зөрүү сөрөг болсноос 15 сарын дараа эдийн засгийн хямрал болдог байна. Энэ үеэр хөрөнгийн зах зээл дунджаар 7% өссөн байна.

Эх сурвалж: [www.edwardjones.com](http://www.edwardjones.com)

# ДЭЛХИЙН ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДАЛ

Шинжээчдийн 2022 оны эхээр үзэж байснаар АНУ-ын эдийн засаг сэргэж байгаа тул бодит ДНБ-ний өсөлт энэ жил 3.5%-4.0% байна гэж таамаглаж байсан. Харин одоо 3 сарын дараа өндөр инфляцын түвшин болон дайны нөхцөл байдлыг таамаглалдаа тусган бодит өсөлтийг 2.5%-3.0% болгон буурав.

Өгөөжийн зөрүү сөрөг болсон огноо	Өгөөжийн зөрүү сөрөг болсноос хэдэн сарын дараа хямрал болсон	Өгөөжийн зөрүү сөрөг болоход S&P 500 хэдэн % өссөн	Өгөөжийн зөрүү сөрөг болсноос хойш хэдэн сарын дараа S&P 500 дээд цэгтээ хүрсэн	S&P 500 индексийн өгөөжийн зөрүү сөрөг болсон тухайн жилийн дээд өсөлтийн %
8/18/1978	17.5	9.6	17.6	9.6
9/12/1980	10.7	3.8	2.6	11.8
12/13/1988	19.6	28.6	19.2	33.4
2/2/2000	14	-18.7	1.7	8.4
1/31/2006	23	14.3	20.4	21.8
8/22/2019	6.3	5.7	6	15.8
<b>Дундаж</b>	<b>15.2 сар</b>	<b>7.20%</b>	<b>11.3 сар</b>	<b>16.80%</b>

Олон улсын эдийн засаг энэ жил өндөр инфляц болон чанга мөнгөний бодлогоос авахуулаад нэлээн хэдэн хүндрэл, бэрхшээлтэй тулгарч байна. Төв банкнууд инфляцын түвшнийг хяналтад авахын тулд бодлогын хүүг өсгөж байгаа нь эдийн засгийн өсөлтийг удаашруулж магадгүй байна. АНУ-ын эдийн засгийн хувьд худалдан авалт болон компанийн ашиг сайн үзүүлэлттэй байгаа тул энэ ондоо ямар нэгэн хямрал болохоор харагдахгүй байна.

## Ийм үед хөрөнгө оруулагчид хэрхэн багцаа бүрдүүлбэл зохих вэ?

Инфляцын түвшинг авч үзвэл бэлэн мөнгө хадгалах нь хамгийн оновчгүй хөрөнгө оруулалт байхаар байна. Түүхээс харахад инфляцын өсөлт компаниудын орлого өсөхөд нөлөөлдөг тул хөрөнгийн зах зээл инфляцын түвшнөөс илүү өсөлттэй байдаг байна. Хөрөнгийн зах зээл дотроо өндөр үнэлгээтэй том компани, улирлын нөлөөтэй компани, мөн сайн санхүүгийн үзүүлэлттэй технологийн компаниудаар багц үүсгэн хөрөнгө оруулах нь хамгийн оновчтой байдаг байна.

Эх сурвалж: [www.edwardjones.com](http://www.edwardjones.com)